

Тvvхэн замнал

Анх 1923-1924оны хичээлийн жилээс Ардын Цэргийн Даргын Сургуулийг (АЦДС) 3 жилийн программтай Цэргийн Бvх Еронхий Сургууль (ЦБЕС) болгон оорчлоход сургалтын толовлогоогоор тоо бодлого, дэлхийн байдал, химийн бэлтгэл зэрэг байгалийн ухааны хичээлvvдийг 90-180 цагт багтаан vздэг байжээ. Агуулгад нь бодис зvйн тухай багтсан *Дэлхийн байдал* хичээлийг 100-120 цаг vзэж байсан нь суралцагчдын танин мэдэхvй , улмаар хувилахуй ухаан (хими)-ы болоод математик, физик сэтгэлгээг хогжvvлэхэд ихээхэн тvlхэц болж байсан байна.

1964 оны тушаалаар Офицер бэлтгэх сургуулийг Цэргийн еронхий сургууль /ЦЕС/ болгон оорчлон зохион байгуулахад мэргэжлийн секцvvдийн бvрэлдэхvvнд Еронхий эрдмийн секцийг байгуулсан нь Математик, мэдээлэл технологийн тэнхимийн vvcэл хогжлийн vндэс суурь болсон тvvхтэй.

БХЯ-ны сайдын 1967 оны н/28 тоот тогтоолоор цэргийн эрдмийн талаар дунд, еронхий боловсролын талаар дээд (тоо, физик, хими) боловсролтой офицер бэлтгэх vургийн хvрээнд 1967 оны 8 сарын 15-нд Еронхий эрдмийн кафедраар (тоо, физик, хими, орос хэлний хичээлийг хариуцсан а/х Ц.Гэлэгпил даргатай, математикийн багш Л.Баторших, Физикийн багш Ш.Тогоо, химийн багш Х.Замандий, орос хэлний багш Н.Цогт, Алла васильевний Татьяна нарын бvрэлдэхvvнтэй) байгуулагджээ. Тэр vеэс дээд тоо: 788-988 цаг, физик: 564-664 цаг, хими: 320-406 цагийн багтаамжтайгаар хичээл сургалтыг явуулж байжээ.

Тус тэнхим нь 2006-2007оны хичээлийн жилд Инженер математик, Хими технологийн мэргэжлээр анхны элсэлтээ авч анхны тогсгчдоо 2010 онд тогсож, анхны бакалаврын зэрэгтэй математикийн болон химийн мэргэжлийн суурьтай цэргийн мэргэжилтэн бэлтгэх эхлэлийг тавьсан.

Анхны дарга Ц.Гэлэгпил нь 1967-1969 ахмад цолтойгоор физик, математикийн кафедрийн даргаар ажиллаж байсан бoгoод МУИС-ийг физикийн мэргэжлээр тогссон. Одон орон судлаач эрдэм шинжилгээний ажитан байсан. 1969 оноос химийн мэргэжилтэй ахлах дэслэгч Цэрэнданзан, 1972-1972онд доктор профессор Ц.Батсуурь, 1974-1988 онд Ш.Тогоо, 1989-2006он хvртэл доктор , профессор Л.Батмонх, 2006-2007,

2008-2010 онд Д.Сайнбаяр нар тэнхимийн эрхлэгч болон даргаар ажиллаж байсан байна. Одоо 2007-2008 болон 2010 оноос хойш ахлах дэслэгч В.Бат-эрдэнэ тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байна. Тус тэнхим мэргэжилтэн бэлтгэж эхэлснээс хойш

- 2010, 2011, 2012, 2013 онуудад Инженер математик, хими технологи мэргэжлээр
- 2014 онд Хими технологи
- 2015 онд Цэргийн хими - хими технологи мэргэжлээр тус тус мэргэжилтэн бэлтгэж гаргасан.

Энэ хичээлийн жилд Артиллери-Хэрэглээний математик мэргэжлийн 2-р дамжааны 28 оюутны мэргэжлийн чиглэлийн хичээл сургалтыг нь зохион байгуулж байгаа бөгөөд хими технологи мэргэжлээр элссэн оюутнууд нь ижил хотолборийн хичээлээр сургалтандаа хамрагдаж байна.

Тэнхимийн бүтэц, бүрэлдэхвүн



-Тэнхимийн дарга,

-Профессор 2

-Дэд профессор 3 (математик, хими, компьютер)

-Ахлах багш 4 (математик-2, хими-экологи, компьютер)

-Багш 8 (математик-2, хими-1, экологи-2, компьютер-3)

Сургалтын материаллаг бааз

Оноогийн байдлаар тус тэнхимийн сургалтын орчин, материаллаг бааз бэхжиж, лабораторийн эрхлэгч, багш-2, математикийн багш-7, химийн багш, компьютер-4, мэдээлэл технологийн үндэсийн багш-5, экологийн багш-2, лабораторийн эрхлэгч-багш-2 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаагийн зэрэгцээ хичээл сургалт, дадлагын лаборатори, ангитанхимийн хүрэлцээ бүрэн хангагдсан болно. Түүний дотор 2015-2016 оны хичээлийн жилд АБС-ийн ИМТ, ЭТ, МЭЗТ, Т болон БХУА, ЦНС, ЦХС, АС-ийн еронхий суурь болоод мэргэжлийн суурь хичээлийн 189 гаруй кредит цагийн хичээл сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, физик- 2, хими-1, компьютер- 4 лабораторийг ашиглаж байна.